



МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2024 оны 04 сарын 12 өдөр

Дугаар А-74

Улаанбаатар хот

Монголбанкны зээлийн мэдээллийн сантай холбоотой зарим арга хэмжээний тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 4 дүгээр зүйлийг 2 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2 дахь заалт, Зээлийн мэдээллийн тухай хуулийн 28.1 дэх хэсгийг тус тус үндэслэн зүдэд нэрвэгдсэн зээлдэгч иргэдэд үүсээд буй санхүүгийн хүндрэлтэй нөхцөл байдал болон Ковид-19 цар тахлаас үүдэн Монгол улсын нийгэм-эдийн засагт үзүүлсэн урт хугацааны сөрөг нөлөөг бууруулах, санхүүгийн үйлчилгээний тэгш, хүртээмжтэй байдлыг хадгалах, эдийн засгийн сэргэлтийг дэмжих зорилгоор ТУШААХ нь:

1. Монголбанкны зээлийн мэдээллийн сантай мэдээлэл солилцох үйл ажиллагааны хүрээнд иргэн, ААН-н зээлийн мэдээллийг зээлийн мэдээллийн лавлагаанд хамруулахгүй байх нөхцөлийг хавсралтаар баталсугай.

2. Тушаалыг хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг Зээлийн мэдээллийн алба (Б.Баасандорж), Мэдээллийн технологийн газар (Б.Хосбаяр)-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитын газар (А.Шижирмаа)-т даалгасугай.


ЕРӨНХИЙЛӨГЧ



Б.ЛХАГВАСҮРЭН

1524010596

Монголбанкны Ерөнхийлөгчийн
2024 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн
А-74 дугаар тушаалын хавсралт



Монголбанкны зээлийн мэдээллийн сантай мэдээлэл солилцох хүрээнд дараах нөхцөлтэй зээлийн мэдээллийг лавлагаанд хамруулахгүй. Үүнд:

1. 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар анхаарал хандуулах, хэвийн бус, эргэлзээтэй болон муу зээлийн ангилалтай, зээл нь бүрэн төлөгдөж дууссан байх.
2. 2024 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс өмнөх байдлаар анхаарал хандуулах, хэвийн бус, эргэлзээтэй болон муу зээлийн ангилалтай, зээл нь бүрэн төлөгдөж дууссан байх.